



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2019 оны 12 сарын 01 өдөр

Дугаар 89

Мандалговь

Нийтлэг үйлчилгээ үйлдвэрийн газрын дүрэм, төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн 18.1.3 ж, Нийтлэг үйлчилгээ үйлдвэрийн газрын дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.3 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг: Нийтлэг үйлчилгээ үйлдвэрийн газрын дүрмийг хавсралтын дагуу баталж, төлөөлөн удирдах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

ТУЗ-ийн дарга
Гишүүд

А.Ганбат /Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга/
Ц.Мөнгөнцоож /Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга/
Б.Гантогтох /Аймгийн ИТХ-ын төлөөлөгч, тэргүүлэгч/
Д.Энхтуяа /Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн Хүнс, худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, хоршооны бодлого хариуцсан мэргэжилтэн/
Л.Дарьбум /Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн/

Хоёр: Хууль тогтоомж, Нийтлэг үйлчилгээ үйлдвэрийн газрын дүрмийг мөрдөж, байгууллагын үйл ажиллагааг сайжруулж, үр дүн гаргаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

Гурав: Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 16 дугаар тогтоол, 2017 оны 07 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  С.СҮХБААТАР





Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2019 оны 01 дугаар сарын
01 өдрийн 89 тогтоолын хавсралт

**“ДУНДГОВЬ АЙМГИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР” ОРОН НУТГИЙН
ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ДҮРЭМ**

НЭГ. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү дүрмийн зорилго нь үйлдвэрийн газрын үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох, удирдлага, хяналт, үйлдвэрийн газрын эд хөрөнгийн эрхийг тодорхойлох, түүнийг өөрчлөн байгуулах, бүртгүүлэх болон холбогдох үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн зохицуулахад оршино.
- 1.2. Дундговь аймгийн “НҮҮГ” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар (цаашид “Газар” гэх) үйлчилгээг үзүүлэх, удирдан чиглүүлэх чиг үүрэг бүхий орон нутгийн өмчөөс олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан үйл ажиллагаа явуулдаг үйлдвэрийн газар мөн.
- 1.3. Үйлдвэрийн газар нь үйл ажиллагаандаа энэхүү дүрэм болон Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, эрх зүйн актыг мөрдөж ажиллана.

ХОЁР. Газрын оноосон нэр. Оршин байгаа газар

- 2.1 Үйлдвэрийн газар нь оноосон нэртэй байна. Түүний хэлбэр онцлогийг тодорхойлсон товчлол байж болно.
- 2.2 Үйлдвэрийн газрын оршин байгаа газар тодорхой байна.НҮҮГ орон нутгийн өмчит газар нь Сайнцагаан сум 7-р баг АЗДТГ-н №103 өрөө

ГУРАВ. Газрын бэлгэдэл тэмдэг

- 3.1 Үйлдвэрийн газар нь өөрийн бэлгэдэлтэй байхаас гадна албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэнэ.
- 3.2 Бэлгэдэл (туг)-ийн загварыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор баталж Улсын бүртгэлийн хэлтэст бүртгүүлсэн байх бөгөөд түүнийг эзэмших эрхийг үйлдвэрийн газар эдлэнэ.
- 3.3 Тэмдэгээр үйлдвэрийн газрын албан ёсны шийдвэр, албан бичиг, гэрээ хэлцлийг баталгаажуулна.
- 3.4 Тэмдэгийг үйлдвэрийн газрын дарга, эсхүл даргаас итгэмжлэн хариуцуулсан этгээд түшиж ашиглалт хамгаалалт хадгалалтыг хариуцаж болно.

ДӨРӨВ. Газрын зорилго үйл ажиллагааны үндсэн чиглэл үүрэг.

- 4.1.
 - Зочид буудлын үйлчилгээ үзүүлэх
 - Ресторан, цайны газрын үйлчилгээ эрхлэх
 - Ёслол хүндэтгэлийн арга хэмжээ зохион байгуулах
 - Аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэх

- Бичиг хэрэг хэвлэн олшруулах
 - Бэлэг дурсгалын үйлчилгээ үзүүлэх
 - Гадаад, дотоод худалдаа эрхлэх
 - Ажлын байрны тавилга техник хэрэгсэл, материал нийлүүлэх
 - Хүлэмжийн аж ахуй эрхлэх
 - Хүнсний нарийн ногоо тариалах
- 4.2. Үйлдвэрийн газар нь тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагааг холбогдох эрх бүхий байгууллагын зохих зөвшөөрлөөр эрхэлнэ.
- 4.3. Үйлдвэрийн газар нь гадаад, дотоодын холбогдох байгууллагуудтай зохих журмын дагуу харилцаа холбоо тогтоож, хамтран ажиллах, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх эдлэж үүрэг хүлээх, түүнчлэн хуулийн байгууллагад нэхэмжлэгч, хариуцагчаар оролцоно.
- 4.4. Үйлчилгээний нэр төрөл, үнэлгээ, нэгж үнэ, тарифыг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор батлуулж мөрдөнө.
- 4.5. Үйлдвэрийн газар нь эзэмшиж буй орон нутгийн өмч хөрөнгийг Монгол улсын хууль тогтоомжинд нийцүүлэн эдэлгээний хугацаа, ашиглалтын горимыг мөрдөж, түүний хадгалалт, хамгаалалтыг хариуцна.
- 4.6. Үйлдвэрийн газар нь хэрэглэгчидтэй бараа бүтээгдэхүүн нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулж ажиллана.
- 4.7. Үйлдвэрийн газар нь үйл ажиллагааны (бизнес, үйлдвэрлэл санхүүгийн) төлөвлөгөөтэй ажиллана. Бизнес төлөвлөгөөг удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулж, аймгийн Засаг дарга Орон нутгийн өмчийн газартай байгуулах гэрээний үндсэн хэсэгт оруулна.
- 4.8. Үйлдвэрийн газар нь ажиллагсадтай хөдөлмөрийн гэрээ, бусад этгээдтэй ажил гүйцэтгэх гэрээ байгуулж ажиллана.
- 4.9. Үйлдвэрийн газар нь үйл ажиллагаандаа хэрэглэгчдийн эрх ашгийг дээдлэн аль нэг этгээдэд гэрээнд заагдаагүй давуу эрх, хөнгөлөлт үзүүлэхгүй байна.
- 4.10. Үйлдвэрийн газар нь аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэрээр үндсэн үйл ажиллагааны чиглэл, хөрөнгийн зориулалтад өөрчлөлт оруулж болно.

ТАВ. Газрын эд хөрөнгийн эрх

- 5.1. Үйлдвэрийн газар нь эд хөрөнгийн талаар дараах эрх, үүрэгтэй байна:
- 5.2. Үйлдвэрийн газар нь үндсэн хөрөнгийг Аймгийн ИТХ-ын шийдвэрийг үндэслэн олж авах, акталж данснаас хасах, худалдан борлуулах, устгах, шилжүүлэх эрхтэй
- 5.3. Өөрт олгогдсон үл хөдлөх хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмшиж, ашиглана.
- 5.4. Үйлдвэрийн газрын үйл ажиллагааны үр дүнд олсон ашгийн хуульд заагдсан татвар хураамжийг төлсний дараах ашгаас 10 хувиар ноогдол ашгийг төсөвт төвлөрүүлнэ.

ЗУРГАА. Газрын удирдлага

- 6.1. Үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг дарга удирдана. Үйлдвэрийн газрын даргыг аймгийн Засаг дарга томилж, чөлөөлнө.

- 6.2. Дарга нь Хууль тогтоомжид заасан шалгуурыг хангасан байна.
- 6.3. Дарга нь бусад төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн ТУЗ, УЗ-д орох, тэдгээрийн захиргаанд буюу олон нийтийн болон шашны байгууллага, сангийн удирдах ажлыг хавсран гүйцэтгэхийг хориглоно.
- 6.4. Даргын цалинг аймгийн Засаг дарга тогтоож, ур чадварын нэмэгдлийг Засаг даргатай байгуулсан гэрээний дүгнэлтийг харгалзан 25 хүртэлх хувиар олгоно.
- 6.5. Үйлдвэрийн Газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоо, удирдлагын зардлыг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчид баталж хэрэгжилтийг дүгнэнэ.
- 6.6. Үйлдвэрийн газрын дарга нь тухай жилийн ажлын тайланг Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн Хуралд дараа оны 3 сарын 1-ны дотор тайлагнана.
- 6.7. Дарга нь Орон нутгийн өмчийн газартай гэрээ байгуулж аймгийн Засаг даргаар баталгаажуулж хагас бүтэн жилээр дүгнүүлнэ.
- 6.8. Дарга нь дэргэдээ даргад зөвлөх үүрэг бүхий даргын зөвлөл ажиллуулж болно. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг дарга батална.

ДОЛОО. Дарга нь дор дурдсан эрх, үүрэгтэй байна.

- 7.1 Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд, газрын дүрмийн 4.7 –д заагдсан төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжүүлэх, үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг шуурхай удирдлагаар хангах ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хариуцана.
- 7.2. Орон нутгийн өмчийн газар, харилцагч байгууллага, засаг даргатай байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, удирдаж буй газрын хэвийн үйл ажиллагааг хангасны үндсэн дээр санхүү, төлбөрийн чадвар, нэр хүндийг бүх талаар дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа явуулна.
- 7.3. Үйлдвэрийн газрын эрх ашгийг дээдэлж, мэргэжил, ажлын дадлага, туршлагаа бүрэн дайчлан ажиллаж аливаа асуудалд ажил хэрэгч идэвх санаачлагатай үнэнч шударгаар хандан байгууллагын эдийн засгийн үндсэн үзүүлэлт , зорилтот түвшинг биелүүлэх ажил үйлчилгээний чанарыг дээшлүүлж ,ажиллагсдын нийгмийн асуудлыг оновчтой шийдвэрлэж ажиллана .
- 7.4. Ажил үүргээ гүйцэтгэх явцад олж авсан үйл ажиллагааны болон бизнесийн нууцыг чанд хадгалах, хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглахгүй байх.
- 7.5. Баталсан удирдлагын бүтэц, зохион байгуулалтын хүрээнд ажилтнуудын ажил үүргийн хуваарь батлах, ажилтныг ажилд томилж, чөлөөлөх, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах, цалингийн хэмжээ, урамшууллын журмыг тогтооно
- 7.6. Дарга нь Хууль тогтоомжид нийцүүлэн хөдөлмөрийн дотоод журам боловсруулан баталж мөрдүүлнэ.
- 7.7. Үйлдвэрийн газрын дарга нь эрх бүхий байгууллагаас олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, зэргээр үйлдвэрийн газрыг төлөөлнө. Хувийн эрх ашгийн үүднээс байгууллагын нэрийг ашиглан гэрээ хэлцэл хийхгүй байна.
- 7.8. Үйлдвэрийн газрын дарга нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд тушаал гаргана.
- 7.9. Ажилчдын хөдөлмөр хамгаалал болон нийгмийн асуудлыг дотоод журамд заасны дагуу шийдвэрлэнэ.

НАЙМ. Удирдах зөвлөл

- 8.1 Газар нь удирдах зөвлөлтэй байх бөгөөд удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн тогтоолоор томилно.
- 8.2 Удирдах зөвлөл нь холбогдох хууль тогтоомжид заасан эрх үүргийн дагуу үйлдвэрийн газарт төрийн өмчийн төлөөллийг хэргжүүлнэ.
- 8.3 Удирдах зөвлөл нь 5 хүний бүрэлдхүүнтэй байна. Бүрэлдэхүүнд ИТХ-ын төлөөлөл, аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн төлөөлөл, тухайн салбарын үйл ажиллагааны чиглэлийг хариуцсан төрийн захиргааны байгууллагын төлөөлөл, Орон нутгийн өмчийн газрын төлөөлөл байна.
Удирдах зөвлөлийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлүүлнэ.
- 8.4.1 Тухайн жилд үйл ажиллагаагаа өргөтгөх материаллаг баазыг бэхжүүлэх хөтөлбөр боловсруулан хэлэлцэн батлах
- 8.4.2 Газрын дүрэм, дотоод журам болон бүтэц, орон тооны төсөл боловсруулж холбогдох газарт хүргүүлэх
- 8.4.3 Аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилтэнд үнэлгээ дүгнэлт өгч уламжлах
- 8.4.4 Газрын санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, хэтийн болон жилийн бизнес төлөвлөгөөний төслийг хэлэлцэн батлах.
- 8.4.5 Удирдах зөвлөлийн гишүүд дээр дурьдсан үйл ажиллагаа болон үйлдвэрийн газрын үйл ажиллагаатай холбоотой цаг үеийн чанартай аливаа ажилд оролцохдоо идвэхитэй оролцох бөгөөд үйлдвэрийн газраас ямар нэгэн цалин хөлс урамшуулал авахгүй.
- 8.4.5 Удирдах зөвлөлийн хурлыг зарлан хуралдааныг явуулахдаа холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөх.

ЕС. Газрын хяналт

- 9.1. Үйлдвэрийн газар үндсэн болон санхүүгийн үйл ажиллагааг хянах дотоод хяналттай байна. Дотоод хяналтын бүтэц, ажиллах журмыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн дарга батална.
- 9.2. Холбогдох хууль тогтоомж, журмын дагуу үйлдвэрийн газрын үйлдвэрлэлийн болон санхүүгийн үйл ажиллагаанд хөндлөнгийн аудитын байгууллагын дүгнэлт гаргуулна.
- 9.3. Үйлдвэрийн газрын эд хөрөнгийн эзэмшил, ашиглалт, хадгалалт, хамгаалалтанд Орон нутгийн өмчийн газар болон Санхүүгийн хяналт шалгалтын байгууллага хяналт тавьж ажиллана.

АРАВ. Газрын санхүү бүртгэл тайлан

- 10.1. Үйлдвэрийн Газар нь санхүүгийн тайлан, мэдээг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд сар, улирал, жил бүр гаргана.
- 10.2. Үйлдвэрийн газрын санхүүгийн тайлангийн үнэн зөвийг дарга, нягтлан бодогч нар хариуцна.
- 10.3. Үйлдвэрийн газрын нягтлан бодогч нь холбогдох хууль тогтоомжид заагдсан шаардлага хангасан хүн байна.

10.4. Үйлдвэрийн Газрын санхүүгийн жил нь тухайн оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж, мөн оны 12-р сарын 31-ний өдөр дуусгавар болно.

АРВАН НЭГ. Газрын санхүүжилт

11.1. Үйлдвэрийн газрын орлого нь дараах санхүүгийн эх үүсвэрээс бүрдэнэ:

- 11.1.1. Ажил, үйлчилгээнээс олсон бүх орлого;
- 11.1.2. Хандивлагчийн тусламж болон буцалтгүй тусламж;
- 11.1.3. Хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн бусад эх үүсвэр;

АРВАН ХОЁР. Газрын баримт бичгийг хадгалах

12.1. Үйлдвэрийн газар нь байгууллагын үйл ажиллагаанд үүссэн удирдлагын нийтлэг баримт бичгийн хадгалах хугацааны үлгэрчилсэн жагсаалтыг баримталж ажиллана.

АРВАН ГУРАВ. Үйлдвэрийн газрыг татан буулгах

13.1. Үйлдвэрийн газар нь цаашид үр өгөөжөө өгөхгүй нь тодорхой болсон тохиолдолд Аймгийн Засаг даргын саналаар Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид холбогдох хууль тогтоомжид заасан үндэслэл журмын дагуу татан буулгах эсхүл өөрчлөн байгуулна.

АРВАН ДӨРӨВ. Бусад

- 14.1. Хуульд нийцүүлэн дүрэмд тусгаснаас бусад асуудлыг хуулиар зохицуулна.
- 14.2. Үйлдвэрийн газрын дүрэм нь Монгол улсын Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт бүртгэгдсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
- 14.3 Газрын дүрэмд үйл ажиллагааны явцад нэмэлт өөрчлөлт оруулж болно.